



# Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн ТОГТООЛ

1965 оны 6 дугаар  
сарын 1-ний өдөр

Дугаар 190

Улаанбаатар  
хот

Улаанбаатар хотын гүйцэтгэх захир-  
гааны зохион байгуулалт, орон тоо-  
ны тухай

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны зохион байгуулалтыг дор дурьдсанаар батласугай:

- а/зохион зааварлах хэлтэс;
- б/санхүүгийн хэлтэс;
- в/гагээрлийн хэлтэс;
- г/соёлын хэлтэс;
- д/ерөнхий хэлтэс;
- е/цэргийн хэлтэс;
- ж/статистикийн хэлтэс;
- з/хөдөлмөр цалин хөлөний товчоо;
- и/төлөвлөгөөний комисс;
- к/иргэний хамгаалалтын штаб.

2. Улаанбаатар хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргааны орон тоог хэвсгалтын ёсоор 60 нэгээр батласугай.

3. Улаанбаатар хотын районы гүйцэтгэх захиргаад, тэдгээрийн дэргэд ажиллах нүүх, цагдаагийн алба тусгай зориулалтын орон тоо, цалингийн хэмжээг тогтоон батлах өгөхийг Хөдөлмөр, Цалин Хөлөний Улсын Хороо /н. ЛХАМСҮРЭН/-д даалгасугай.

4. Улаанбаатар хотын районы намдын хороо, гүйцэтгэх захиргааны барилгын зураг, төсвийг анх онд багтаан хийлгэж өгөхийг Улсын Барилгын Зөвлөл/н. БАВУУДОРГ/-д даалгасугай.

2.

5. Улаанбаатар хотын районы ардын депутатуудын хурлын дүнийг боловруулж, энэ оны 6 дугаар сарын 15-ны дотор Сайд нарын Зөвлөлд оруулахыг Улаанбаатар хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаа/н.ЛУВСАНЧОЙМБОЛ/-д даалгасугай.

6. Улаанбаатар хотын районы гүйцэтгэх захиргааны албан ажлын хэрагцээнд зориулж, дуудлагын автомашины 4-ийг хэраглуулахыг зөвшөөрсүгэй.

Б Н М А Улсын Сайд нарын  
Зөвлөлийн орлогч дарга

ЛҮГЭРСҮРЭН

Б Н М А Улсын Сайд нарын  
Зөвлөлийн Хэрэг эрхлэх  
газрын дарга

БАДАГ



Хуулбар үнэн: Тогтоол ангийн  
эрхлэгч

*О.Адогз* / ДАГВАДОРЖ /

Сайд нарын Зөвлөлийн  
1965 оны 190 дүгээр  
ТОГТООЛЫН ХАВСРАЛТ

Улаанбаатар хотын ардын депутатуудын  
хурлын гүйцэтгэх захиргааны орон тоо

№ : Албан тушаал	орон тоо
1. Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны дарга	1
2. I дүгээр орлогч дарга бөгөөд төлөвлөгөөний комиссын дарга	1
3. Орлогч дарга бөгөөд газрын дарга	3
4. Орлогч дарга	1
5. Хариуцлагатай нарийн бичгийн дарга бөгөөд зохион зааварлах хэлтсийн дарга	1
6. Төлөвлөгөөний комиссын орлогч дарга	1
7. Хэлтсийн дарга	5
8. Товчооны дарга	2
9. Штабын дарга	1
10. Цэргийн хэлтсийн ба штабын туслах	4
11. Тасгийн дарга	1
12. Ерөнхий нягтлан бодогч	1
13. Мэргэжилтэн	13
14. Референт	1
15. Улсын байцаагч	1
16. Зааварлагч, байцаагч	9
17. Нягтлан бодогч	1
18. Тогтоол ангийн эрхлэгч	1
19. Дэргын ба ШБОО-ны нарийн бичгийн дарга	2
20. Бичиг хэргийн эрхлэгч	1
21. Бичээч	3
22. Архивын эрхлэгч	1
23. Архивын фондоч	1
24. Комендант-мөнгөний нярав	1
25. Оператор-бичээч	1